

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/113/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: Т.Намжил
Утас: 70453721, Цахим хаяг: NamjilT@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан	2
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
ЛАБОРАТОРИ 1 ДҮГЭЭР
ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.ЦЭРЭНДУЛАМ
ТАНАА

2022.02.24 № УВА-2022/113/НА-СТА-ТШЗ
танай -ны № -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн заагийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  БАТСУУРЬ



0200200193

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	258,680,114.42	330,637,668.80
33	АВЛАГА		38,563,986.00
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага		36,543,736.00
3351	Байгууллагаас авах авлага		2,020,250.00
35	БАРАА МАТЕРИАЛ	258,680,114.42	292,073,682.80
35100	Түүхий эд материал	59,044,626.51	64,081,908.39
35110	Тусгай зориулалттай материал	58,899,126.51	63,513,608.39
35130	Эм боох материал	145,500.00	568,300.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл		
35300	Бэлэн бүтээгдэхүүн		
35400	Хангамжийн материал	199,635,487.91	227,991,774.41
35410	Бичиг хэргийн материал	10,822,357.50	15,051,663.00
35420	Аж ахуйн материал	18,033,000.00	25,849,500.00
35430	Сэлбэг хэрэгсэл		
35440	Түлш, шатах тослох материал	1,800,000.00	1,350,000.00
35450	Барилгын засварын материал	590,500.00	590,500.00
35460	Хүнсний материал	108,900.00	90,500.00
35470	Бусад хангамжийн материал	168,280,730.41	185,059,611.41
35500	Биологийн хөрөнгө		
35600	Мал амьтад		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,863,139,538.86	4,655,019,750.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,863,139,538.86	4,655,019,750.04
39100	Газар		
39200	Биет хөрөнгө	4,191,439,538.86	3,983,319,750.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,291,386,063.00	4,291,386,063.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-408,866,240.91	-613,247,754.63
39203	Авто-тээврийн хэрэгсэл		
39204	Хуримтлагдсан элэгдэл		
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	616,378,527.26	665,782,166.26
39206	Хуримтлагдсан элэгдэл	-531,451,117.83	-550,106,201.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	259,234,108.67	256,770,079.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	-165,579,107.64	-187,482,032.57
39209	Зам, гүүрийн байгууламж		
39210	Хуримтлагдсан элэгдэл		
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж		
39212	Хуримтлагдсан элэгдэл		
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс		
39214	Бусад үндсэн хөрөнгө	159,449,890.01	162,318,518.17

39215	Хуримтлагдсан элэгдэл	-107,491,304.90	-127,911,009.60
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	78,378,721.20	85,809,921.20
39300	Биет бус хөрөнгө	671,700,000.00	671,700,000.00
39301	Програм хангамж	3,592,150.00	3,592,150.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,592,150.00	-3,592,150.00
39303	Бусад биет бус хөрөнгө	671,700,000.00	671,700,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл		
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,121,819,653.28	4,985,657,418.84
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	311,139.00	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	311,139.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,121,508,514.28	4,985,657,418.84
51	Засгийн газрын хувь оролцоо	5,121,508,514.28	4,985,657,418.84
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,213,975,804.87	3,213,975,804.87
51200	Хуримтлагдсан үр дүн	601,093,603.61	472,758,843.17
51210	Өмнөх үеийн үр дүн	601,093,603.61	608,609,938.61
51220	Тайлант үеийн үр дүн		-135,851,095.44
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,306,439,105.80	1,298,922,770.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,121,819,653.28	4,985,657,418.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,704,646,047.08	3,887,450,955.94
	ТАТВАРЫН ОРЛОГО	115,470,834.57	11,891,940.06
	Хувь хүний орлогын албан татвар	115,470,834.57	11,891,940.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,575,190,212.51	3,837,231,223.88
120	Нийтлэг татварын бус орлого	68,232,612.51	35,054,875.88
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,832,500.00	24,908,394.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,832,500.00	24,908,394.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	115,470,834.57	11,891,940.06
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Бараа материал	58,400,112.51	10,146,481.88
	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	3,506,957,600.00	3,802,176,348.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	3,055,748,600.00	3,286,812,500.00
122005	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	451,209,000.00	515,363,848.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,985,000.00	38,327,792.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,985,000.00	38,327,792.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,370,850.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,655,000.00	10,597,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	330,000.00	21,359,442.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,838,025,363.81	4,023,302,051.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,838,025,363.81	4,023,302,051.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,681,106,871.81	3,889,780,080.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,494,008,735.00	2,671,842,686.00
210101	Үндсэн цалин	1,669,069,464.00	1,611,613,562.00
210102	Нэмэгдэл	609,071,100.00	906,893,800.00
210104	Урамшуулал	215,868,171.00	153,335,324.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	310,681,128.00	341,502,333.00
210201	Тэтгэврийн даатгал	211,263,115.00	233,034,638.00
210202	Тэтгэмжийн даатгал	24,854,779.00	28,765,598.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,883,483.00	21,284,876.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,970,895.00	5,384,015.00
210205	Эрүүл мэндийн даатгал	49,708,856.00	53,033,206.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	438,513,867.00	498,865,448.00
210301	Гэрэл, цахилгаан	12,114,529.00	10,771,822.00
210302	Түлш, халаалт	403,464,600.00	458,345,680.00
210303	Цэвэр, бохир ус	22,934,738.00	29,747,946.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,785,706.25	21,063,441.00
210401	Бичиг хэрэг	1,412,970.00	1,892,950.00
210402	Тээвэр, шатахуун	2,067,900.00	1,817,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,586,189.00	3,248,891.00
210404	Ном, хэвлэлийн зардал	1,176,710.00	439,200.00
210405	Хог хаягдал, устгах цэвэрлэх	3,540,000.00	2,987,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,837,800.00	10,677,500.00
210408	Бараа материал акталсны зардал	5,164,137.25	
2105	Нормативт зардал	46,494,130.00	32,663,760.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,462,950.00	577,000.00
210502	Хоол, хүнс	45,031,180.00	32,086,760.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,124,165.00	12,995,700.00
210604	Урсгал засвар	9,124,165.00	12,995,700.00
2107	Томилолт, зочны зардал	949,400.00	1,349,500.00
210702	Дотоод албан томилолт	949,400.00	1,349,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,784,450.00	6,107,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,059,450.00	4,277,600.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	725,000.00	1,829,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210807	Газрын төлбөр		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	352,765,290.56	303,389,712.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	20,153,277.50	15,156,444.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	332,612,013.06	288,233,267.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	156,918,492.00	133,521,971.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,341,010.00	87,718,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,716,010.00	76,301,050.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,625,000.00	11,417,250.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох татаас, санхүүжилт	97,743.00	42.00
	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,483.00	
	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	42,260.00	42.00
	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	89,479,739.00	45,803,629.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-133,379,316.73	135,851,095.44
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-133,379,316.73	135,851,095.44

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,530,775,100.00	3,865,412,534.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,516,790,100.00	3,827,084,742.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,832,500.00	24,908,394.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,832,500.00	24,908,394.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,832,500.00	24,908,394.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		
	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	3,506,957,600.00	3,802,176,348.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	3,055,748,600.00	3,286,812,500.00
122005	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	451,209,000.00	515,363,848.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,985,000.00	38,327,792.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,985,000.00	38,327,792.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		1,370,850.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,655,000.00	10,597,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	330,000.00	21,359,442.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,530,775,100.00	3,865,412,534.00

21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,530,775,100.00	3,865,412,534.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,374,151,408.00	3,729,870,313.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,492,111,153.00	2,687,285,294.00
210101	Үндсэн цалин	1,667,171,882.00	1,626,678,394.00
210102	Нэмэгдэл	609,071,100.00	906,893,800.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	215,868,171.00	153,713,100.00
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	310,681,128.00	362,914,600.00
210201	Тэтгэврийн даатгал	211,263,115.00	255,384,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	24,854,779.00	26,882,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,883,483.00	21,506,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,970,895.00	5,376,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	49,708,856.00	53,765,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	440,313,867.00	498,415,448.00
210301	Гэрэл, цахилгаан	12,114,529.00	10,771,822.00
210302	Түлш, халаалт	405,264,600.00	457,895,680.00
210303	Цэвэр, бохир ус	22,934,738.00	29,747,946.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,035,510.00	43,435,052.00
210401	Бичиг хэрэг	2,191,600.00	3,769,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,930,000.00	1,839,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,586,189.00	3,248,891.00
210404	Ном хэвлэл	10,656,801.00	7,879,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	4,699,000.00	7,246,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,971,920.00	19,452,261.00
2105	Нормативт зардал	43,461,450.00	35,085,880.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	999,650.00	999,800.00
210502	Хоол, хүнс	39,431,800.00	32,218,360.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,030,000.00	1,867,720.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,894,650.00	77,738,739.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,740,000.00	58,379,339.00
210602	Тавилга	9,315,000.00	2,411,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	10,839,650.00	16,948,400.00
2107	Томилолт, зочны зардал	949,400.00	1,349,500.00
210702	Дотоод албан томилолт	949,400.00	1,349,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,843,250.00	6,107,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,118,250.00	4,277,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	725,000.00	1,829,900.00
210807	Газрын төлбөр		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,861,000.00	17,538,300.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,861,000.00	17,538,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	156,623,692.00	135,542,221.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	67,046,210.00	89,738,550.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,421,210.00	76,151,050.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,625,000.00	13,587,500.00
	Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох татаас, санхүүжилт	97,743.00	42.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,483.00	
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	42,260.00	42.00
	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	89,479,739.00	45,803,629.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,479,739.00	45,803,629.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
2200	Дотоод эх үүсвэрээр		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	3,213,975,804.87	1,305,233,384.80	734,472,920.34	5,253,682,110.01
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0

3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,213,975,804.87	1,305,233,384.80	734,472,920.34	5,253,682,110.01
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				1,205,721.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчилөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн			-133,379,316.73	-133,379,316.73
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,213,975,804.87	1,306,439,105.80	601,093,603.61	5,121,508,514.28
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			7,516,335.00	7,516,335.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,213,975,804.87	1,306,439,105.80	608,609,938.61	5,129,024,849.28
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		-7,516,335.00		-7,516,335.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчилөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн			-135,851,095.44	-135,851,095.44
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,213,975,804.87	1,298,922,770.80	472,758,843.17	4,985,657,418.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,827,944,594.00	3,781,281,113.00	46,663.481	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,827,944,594.00	3,781,281,113.00	46,663.481	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,723,931,594.00	3,693,585,063.00	30,346,531.00	99.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,687,285,294.00	2,687,285,294.00	0.00	100.0 0
210101	Үндсэн цалин	1,626,678,394.00	1,626,678,394.00	0.00	100.0 0

210102	Нэмэгдэл	906,893,800.00	906,893,800.00	0.00	100.00
210104	Урамшуулал	153,713,100.00	153,713,100.00	0.00	100.00
210105	Гэрээт ажлын хөлс			0.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	362,914,600.00	362,914,600.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	255,384,200.00	255,384,200.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	26,882,600.00	26,882,600.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,506,100.00	21,506,100.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	5,376,500.00	5,376,500.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	53,765,200.00	53,765,200.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	498,668,700.00	498,415,448.00	253,252.00	99.95
210301	Гэрэл, цахилгаан	9,907,000.00	10,771,822.00	-864,822.00	108.73
210302	Түлш, халаалт	457,895,700.00	457,895,680.00	20.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	30,866,000.00	29,747,946.00	1,118,054.00	96.38
2104	Хангамж, бараа материалын зардал	34,777,100.00	34,768,591.00	8,509.00	99.98
210401	Бичиг хэрэг	2,040,000.00	2,039,600.00	400.00	99.98
210402	Тээвэр, шатахуун	1,688,700.00	1,688,700.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,249,700.00	3,248,891.00	809.00	99.98
210404	Ном хэвлэл	7,882,800.00	7,879,400.00	3,400.00	99.96
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	6,620,000.00	6,616,100.00	3,900.00	99.94
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,295,900.00	13,295,900.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	53,614,500.00	35,085,880.00	18,528,620.00	65.44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	999,800.00	999,800.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	50,746,100.00	32,218,360.00	18,527,740.00	63.49
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,868,600.00	1,867,720.00	880.00	99.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,690,000.00	55,083,400.00	606,600.00	98.91
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,485,000.00	36,485,000.00	0.00	100.00
210602	Тавилга	1,650,000.00	1,650,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	17,555,000.00	16,948,400.00	606,600.00	96.54

2107	Томилолт, зочны зардал	1,420,800.00	1,349,500.00	71,300.00	94.98
210702	Дотоод албан томилолт	1,420,800.00	1,349,500.00	71,300.00	94.98
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,229,600.00	3,352,500.00	877,100.00	79.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,628,600.00	2,627,600.00	0.00	
210802	Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	876,000.00		876,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар			0.00	
210806	Мэдээлэл технологийн зардал	725,000.00	724,900.00	100.00	99.99
210807	Газрын төлбөр			0.00	
	Бараа үйлчилгээний бусад зардал	25,331,000.00	15,329,850.00	10,001,150.00	60.52
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,331,000.00	15,329,850.00	10,001,150.00	60.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	104,013,000.00	133,499,679.00	29,486,679.00	- 128.35
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг			0.00	
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг			0.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	104,013,000.00	87,696,050.00	16,316,950.00	84.31
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал			0.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	92,464,800.00	76,151,050.00	16,313,750.00	82.36
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж			0.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг			0.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,548,200.00	11,545,000.00	3,200.00	99.97
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,827,944,594.00	3,827,084,742.00	859,852.00	99.98
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,286,812,500.00	3,286,812,500.00	0.00	100.00
	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	3,286,812,500.00	3,286,812,500.00	0.00	100.00
	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	516,223,700.00	515,363,848.00	859,852.00	99.83
	Орон нутгийн төсвөөс	516,223,700.00	515,363,848.00	859,852.00	99.83
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	24,908,394.00	24,908,394.00	0.00	100.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,908,394.00	24,908,394.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		38,327,750.00	38,327,750.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ		38,327,750.00	38,327,750.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		36,285,250.00	36,285,250.00	
2104	Хангамж, бараа материалын зардал		8,666,461.00	8,666,461.00	
210401	Бичиг хэрэг		1,729,400.00	1,729,400.00	
210402	Тээвэр, шатахуун		150,700.00	150,700.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгах		630,000.00	630,000.00	
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс		6,156,361.00	6,156,361.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		22,655,339.00	22,655,339.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл		21,894,339.00	21,894,339.00	
210602	Тавилга		761,000.00	761,000.00	
210604	Урсгал засвар				
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр		2,755,000.00	2,755,000.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,650,000.00	1,650,000.00	
210806	Мэдээлэл технологийн зардал		1,105,000.00	1,105,000.00	
	Бараа үйлчилгээний зардал		2,208,450.00	2,208,450.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,208,450.00	2,208,450.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,042,500.00	2,042,500.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг		2,042,500.00	2,042,500.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		2,042,500.00	2,042,500.00	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		38,327,792.00	38,327,792.00	
31	Нэмэлт санхүүжилтийн орлого		38,327,792.00	38,327,792.00	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,370,850.00	1,370,850.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		5,000,000.00	5,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,597,500.00	10,597,500.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		21,359,442.00	21,359,442.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Намжил гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Увс аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр цогцолбор сургууль нь Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр цогцолбор сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,838,025.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 76,760.5 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,023,302.0 мянган төгрөгийн 2 хувиар буюу 80,466.0 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 64,372.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд Увс аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр цогцолбор сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 136,162.2 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оноос өөрчлөлт орсон авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0	38,564.0	38,564.0
Урьдчилгаа			
Бараа материал	258,680.1	292,073.7	33,393.6
Үндсэн хөрөнгө	4,863,139.5	4,655,019.7	-208,119.8
Нийт хөрөнгө	5,121,819.6	4,985,657.4	-136,162.2
Өр төлбөр	311.1	0	-311.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,121,508.5	4,985,657.4	-135,851.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,121,819.6	4,985,657.4	-136,162.2

Авлага дансны үлдэгдэл 38,564.0 мянган төгрөг болж 38,564.0 мянган төгрөгөөр өссөн нь Цалин, НДШ-ийн хэмнэлтийг татвар, нийгмийн даатгалд шилжүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 292,073.7 мянган төгрөг болж 33,393.6 мянган төгрөгөөр өссөн нь Боловсролын яамнаас хөрөнгө оруулалтаар ирсэн хими, физикийн урвалж бодис, жижиг багаж хэрэгсэл, бага ангийн сургалтын хэрэглэгдэхүүн зэргийг тусгай зориулалтын материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материалын дансанд бүртгэгдсэнээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,655,019.7 мянган төгрөг болж 208,119.8 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл болон акталсан үндсэн хөрөнгөөс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 68,221.5 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 11,891.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 22,874.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 311.1 мянган төгрөгөөр буурсан нь НДШ-ийн өглөгийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,985,657.4 мянган төгрөг болж 135,851.1 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 182,804.9 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан үндсэн үйл ажиллагааны орлого, үнэ төлбөргүй хүлээж авсан хөрөнгө, материал болон нэмэлт санхүүжилтийн дансны орлого байна. Энэ нь салбар яамнаас хөрөнгө оруулалт хийгдсэн, төсөл хөтөлбөр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 185,276.7 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өсөхөд цалин, НДШ, түлш халаалт, цэвэр бохир ус, эд хогшил, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн хоол, хичээл практик, урсгал шилжүүлэг зэрэг зардал голчлон нөлөөлжээ. Энэ нь 2019, 2020 онд хичээл сургалтын үйл ажиллагаа ковид-19 цар тахалтай холбоотой өссөн болон буурсан харагдаж байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,135,485.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,135,485.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 307,540.6 мянган төгрөгөөр бууруулж 3,827,944.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 121,936.2 мянган төгрөгийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, тэтгэвэр гарахад нэг удаа олгох тэтгэмжийн зардлыг аймгийн Боловсрол соёлын газарт авч үлдсэн болон цалин, НДШ, бусад зардалд 185,604.4 мянган төгрөг төсөвлөснөөс дутуу батлагдаж иржээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,827.944.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 3,286,812.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 516,223.7 мянган төгрөгийн орон нутгийн төсвөөс, 24,908.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,286,812.5 мянга, орон нутгийн төсвөөс 515,363.8 мянган төгрөг авч, үндсэн үйл ажиллагааны орлогоос 24,908.4 мянган төгрөг оруулж, нийт 3,827,084.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,781,281.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үндсэн үйл ажиллагааны данснаас 45,803.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3,781,281.1 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 10,597.5 мянга, ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс 5,000.0 мянга, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 1,370.9 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 21,359.4 мянган нийт 38,327.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэрэг зардал 1,729.4 мянга, тээвэр шатахуун зардалд 150.7 мянга, хог хаягдал, хортон мэрэгчдийн устгал зардалд 630.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс зардалд 6,156.3 мянга, багаж техник хэрэгсэл зардалд 21,894.3 мянга, тавилга, эд хогшлын зардалд 761.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 1,650.0 мянга, мэдээлэл технологийн зардалд 1,105.0 мянга, хичээл үйлдвэрлэл дадлага хийх зардалд 2,208.4 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 2,042.5 мянга, нийт 38,327.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн данснаас 0.04 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр цогцолбор сургуулийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 138 мэдээллийг хугацаандаа 11 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна. Мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд Увс аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр цогцолбор сургуулийн санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цалингаас суутгасан хувь хүний орлогын албан татварын 30,816.0 мянган төгрөгийг 100150000901 тоот Суутган-1 дансанд шилжүүлэхгүйгээр хувь хүнээс суутгасан орлогын албан татварын 100151900912 тоот дансанд шилжүүлсэн байна. Дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

4.1 Залруулсан алдаа

1. Боловсрол, шинжлэх ухааны яамны “Боловсрол чанарын шинэчлэл” төслийн хүрээнд хийгдээгүй ажлын санхүүжилт 1,838.2 мянган төгрөгийг сургуулийн нярвын дансанд шилжүүлснийг санхүүгийн тайланд авлага тусгуулан залруулга хийлгэв.

4.2 Төлбөрийн акт

1. Увс аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр цогцолбор сургуулийн багш Л.Баяржаргалд сахилгын шийтгэл тооцох хугацаа дуусаагүй байхад 3, 4-р улирлын үр дүнгийн урамшуулалд нийт 363.8 мянган төгрөг олгосон байсанд төлбөрийн акт тогтоосон.

4.3 Зөвлөмж

1. *Авлагын данстай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтад “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчин цалингийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэлд 15,131.5 мянга, ашгийн татварт 7,125.8 мянга, Нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас нийгмийн нийгмийн даатгалын шимтгэлд 14,286.5 мянган төгрөгийг илүү шилжүүлж нийгмийн даатгалын авлага 29,417.9 мянга, татварын авлага 7,125.8 мянга, нийт 36,543.7 мянган төгрөгийг авлага үүсгэсэн байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Увс аймгийн Ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр цогцолбор сургууль	3	38,745.7	1	1,838.2	1	363.8			1	36,543.7

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР



М.БАТСУУРЬ/

М.БАТ-АМГАЛАН/

Г.НАМЖИЛ/

2022 оны 02 сарын 22-ны өдөр